



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-18
Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа	4-18

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
3 дугаар сарын 16-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Н.Учрал хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 101 гишүүн хүрэлцэн ирж, 80.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ц.Даваасүрэн, Б.Тулга, Ч.Ундрам;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, О.Саранчулуун;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-06 минут, Н.Алтаншагай-01 минут, С.Амарсайхан-02 минут, Х.Баасанжаргал-01 минут, Д.Батлут-02 минут, Ж.Батсуурь-02 минут, Ж.Баярмаа-03 минут, Ж.Баясгалан-07 минут, Б.Бейсен-05 минут, Г.Дамдинням-04 минут, Б.Жавхлан-03 минут, Б.Жаргалан-10 минут, Г.Лувсанжамц-01 минут, Б.Мөнхсоёл-01 минут, О.Номинчимэг-02 минут, Н.Номтойбаяр-06 минут, Б.Пунсалмаа-20 минут, Г.Уянгахишиг-18 минут, О.Цогтгэрэл-08 минут.

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
нээлтийн ажиллагаа**

“Их хуралдай” танхим дахь Монгол Төрийн далбааны дэргэд Хүндэт харуул зогсож, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, Монгол Улсын Их Хурлын дарга Н.Учрал, Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүд суудлаа эзэлсэн байлаа.

Танхимд байрлах дэлгэцүүд дээр “МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ НЭЭЛТ, 2026.03.16” гэж бичсэн байв.

Танхимын баруун хойд талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан;

Зүүн хойд талд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ;

Зүүн урд талд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан, Монгол Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Д.Ганзориг, Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, мөн газрын дэд дарга Г.Эрдэнэбат, Л.Дашдэмбэрэл, Захиргааны удирдлага, хүний нөөцийн газрын дарга П.Баттөр, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалтын газрын дарга Д.Энхбат, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга Б.Төгсбаяр, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, Гадаад харилцааны газрын дарга П.Баярмагнай, Гүйцэтгэл, бүтээмжийн хяналтын хэлтсийн дарга Ж.Гантулга, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга Ч.Сарангэрэл,

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Ажлын албаны дарга Б.Энхмөнх, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Онолт;

Баруун урд талд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга П.Золзаяа, Шүүхийн сахилгын хорооны дарга С.Энхтөр, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын даргын Ажлын албаны дарга Э.Тамир, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Цолмон, зөвлөх С.Тэнгис, С.Энхболд, Б.Анар, Б.Булганчимэг, Б.Ганбат, М.Чимгүүндарь, Г.Ирээдүй, Ч.Золбаяр, Б.Дөлгөөн;

Танхимын дээд давхарт Монгол Улсад суугаа гадаад орнуудын Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын тэргүүн нар болон Монгол Улсын иргэдийн төлөөлөл тус тус суудлаа эзэлсэн байв.

Улсын Их Хурлын дарга Н.Учрал Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүд болон нээлтийн ажиллагаанд оролцогсад босож хүндэтгэл үзүүлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх үг хэлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч үг хэлж дуусахад Улсын Их Хурлын дарга Н.Учрал Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд талархал илэрхийлж, Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

Хуралдаан 47 минут үргэлжилж, 126 гишүүнээс 120 гишүүн хүрэлцэн ирж, 95.2 хувийн ирцтэйгээр 10 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2026 оны 3 дугаар сарын 16-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 03 минут.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Учрал: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгаж мэндчилье. Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх, Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Засгийн газрын гишүүд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Нийслэлийн удирдлагууд, Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нар зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд, Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын тэргүүн нар болон иргэдийн төлөөлөл оролцож байна.

Эрхэм хүндэт ард иргэд ээ,

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч өө,

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүндэт зочид оо, та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгаж мэндчилье. Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулган онцгой цаг үе, нөхцөл байдалд эхэлж байна. 1 дүгээрт, 2024 оны сонгуулиар улс төрийн 5 нам, эвсэл, нийгмийн сонирхлын олон бүлгийн төлөөллөөс бүрдсэн 126 гишүүнтэй Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа энэ хаврын чуулганаар талдаа орлоо. Үлдсэн цаг хугацаанд өндөр хариуцлагатай, үр бүтээлтэй, идэвх санаачилгатай ажиллахыг та биднээс цаг хугацаа шаардаж байна.

2 дугаарт, дэг журам нь сулран ганхаж, төмөр хөшиг ахин татагдаж, хүчний туйл нь өөрчлөгдөж байгаа дэлхийн цаг төрийн ээдрээ, геополитикийн зөрчил мөргөлдөөн, дайн байлдаан, тээвэр логистикийн хямрал, эрчим хүч, энергийн хомсдолын шинэ сорилтуудтай дэлхийн Монгол Улс тулгарч байна. Далайд гарцгүй, цөөн түүхий эдээс хамаарсан экспорт, түлш шатахууны хараат байдалтай орны хувьд уулын цаана уул, уулсын цаана уулс байгааг харж, үндэстний эв нэгдэл, язгуур эрх ашгаа эрхэмлэн дээдэлж, сөрөн тэсвэрлэх чадавхаа бататгаж, тусгаар тогтнолоо эдийн засгийн тусгаар тогтнолоор дархлахыг хувиран өөрчлөгдөж байгаа дэлхийн нөхцөл байдал та биднээс шаардаж байна. Дэлхийн цаг төрийн хурцадмал нөхцөл байдал, сорилтуудын өмнө нам, бүлгээрээ талцан хуваагдах бус гагцхүү улс орны эрх ашиг, шударга ёсон дээр суурилан эвлэлдэн нэгдэхийг цаг үе та биднээс шаардаж байна.

3 дугаарт, ардчилсан парламентын дархлаа парламентын танхимаасаа эхлэн батжин бэхжиж байх учиртай. Улсын Их Хурлын танхимаас хулгайч биш, хууль төрж байх ёстой гэдэг үгээ дахин давтан хэлэхийг хүсэж байна. Үндсэн хуульд өргөсөн тангарагтаа үнэнч байж, биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас хэмээх өв сургаалыг санаж, үлгэр дуурайлал үзүүлэхийг ардчилсан төрийн жинхэнэ эзэд, эх булаг нь болсон ард түмэн та биднээс шаардаж байна. Иргэнээсээ илүү тусгай дархан эрх эдэлдэггүй, ил тод, нээлттэй, бүтээлч, хариуцлагатай, авлигаас ангид, ардчилсан парламентын нэр хүндийг өндөрт өргөж, ард түмнийхээ итгэлийг эвдэхгүй, сэтгэлийг нь сэвтээхгүй ямагт ёс зүйн өндөрлөг дээрээ ажиллаж, парламентын дархлаагаа хадгалан хамгаалах нь цаг үеийн шаардлага, цадиг түүхийн сургамж юм.

4 дүгээрт, нийгмийн хэрэгцээ шаардлага, нийт олны хүсэн хүлээлт дагуулсан хурж овоорсон асуудал бэрхшээлийг тууштай, оновчтой тулж шийдэхийг та биднээс амьдрал өөрөө шаардаж байна. Эрх чөлөө бол ардчилсан нийгмийн эрүүл агаар билээ. Эрх чөлөө бол иргэн ба төрийн итгэлцлийн гагнаас юм. Үндсэн хуульд заасан хүний заяагдмал жам ёсны үндсэн эрхийг дархлан хамгаалж, эдийн засгийн эрх чөлөөгөө эдлэхэд нь чөдөр тушаа болсон төрийн хүнд суртал, хууль журмын хийдэл, давхардал, гох дэгээг тайлж, хийе, бүтээе, хөдөлмөрлөө гэсэн хэн бүрийн ачааг хөнгөлж, саадыг чөлөөлөхийг хүслээ хясуулсан Монгол хүн бүхэн та биднээс нэхэн шаардаж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын чуулганы завсарлагаагаар миний бие Улсын Их Хурлын гишүүдийн хамт зүүн, төв, хангай, хойд бүсэд ажиллаж 8200 гаруй иргэнтэй нүүр тулан нээлттэй уулзаж, илэн далангүй харилцан ярилцлаа. Ажил амьдралд нь тулгамдсан асуудал бэрхшээлийн талаарх санал бодлыг нь сонсож, хууль тогтоомж хэрхэн хөрсөн дээрээ хэрэгжиж байгаатай танилцаж, хаврын чуулганаар хэлэлцэх хууль, шийдвэрийн талаар мэдээлэл өгч, санал бодлыг нь нээлттэй сонслоо. Малчид малчны тухай, ахмадууд ахмад настны болон тэтгэврийн тухай, эмч, багш нар, соёлын салбарынхан цалин хөлсний нэмэгдэл, эцэг эхчүүд, олон нийт Хүүхэд хамгааллын тухай хуулийн биелэлтийг нэхэж, шуурхай нэг мөр хэрэгжүүлэхийг шаардаж байна. Очсон аймаг, сум, уулзсан хүн бүр шахам улс орон даяар гал алдсан, эрчим хүчний доголдлыг хөндөж, 10 аймагт хөнгөлөлттэй зээлээр дулааны станц барих ажил царцаж гацсанд харамсан бухимдаж, аймгийн төвүүд агаарын бохирдол ихтэй өвөлжлөө.

Аймаг, орон нутагт ард иргэд бүгдээрээ эдийн засгийн эрх чөлөөгөө эдлэх, бусдаас үл хамааран бие даан бүтээж босгох, ажиллаж хөдөлмөрлөх, төвлөрсөн эрх мэдэл, төсвийн хэт хамаарал, хүнд суртлын хүлээснээс чөлөөлөгдөх хүсэл дүүрэн байна. Энэ бол хийж бүтээх санаа, шийдэл, эдийн засгийн бие даасан байдал, эрх чөлөөгөө эдлэх эрүүл хүчтэй хүсэл шаардлага юм. Аймаг, сумдаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөө ахиу үлдээвэл хамгийн их хэрэгцээ шаардлагатай, бүх хүнд илүү өгөөжтэй, хүртээмжтэй, хурж овоорсон, хүсэн хүлээлт дагуулсан асуудлаа өөрсдөө шийдэх боломж бүрдэнэ гэдгийг тэд хэлж байна. Засгийн газар байгалийн баялгаа ашиглуулж байгаа аймаг, сумдад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг илүү хуваарилах эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь цаг хугацааны шалгуур болон хувирчээ. Хөдөөгийнхөн хөдөөдөө хүний дайтай амьдрах орчин нөхцөл нь байвал хот руу олуулаа нүүхгүй. Зам, дэд бүтэц, инженер шугам

сүлжээ барих, малын арьс шир, түүхий эдэд илүү үнэ цэн, өртөг ашиг нэмэх үйлдвэрүүдийн үүдийг нээх, залуу ажиллах боловсон хүчин, малчдын залгамж халааг бэлтгэхэд төр төсвөөс онцгойлон анхаарах шаардлагатайг онцолж байна.

Төрийн албан хаагчдын цомхотгол эзнээ, хүнээ олохгүй байна. Эмч, багш нар цалингийн нэмэгдлийн бодит биелэлт, соёл, урлагийн ажилтнууд, цаг уурын албан хаагчид эзнээ, хүнээ олоогүй цомхотголын улмаас хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсноо ярьж байна. Тиймээс Монгол Улсын Засгийн газар төрийн албан хаагчдын 9 хувийн цомхотголоо эргэн харж, ажлын онцлог, ачааллыг зөв хуваарилан, чиг үүргийн шинжилгээг дахин хийж, эгэл жирийн төрийн албан хаагчдыг цомхотгох бус дарга нарын тоогоо цөөлөх бодлого боловсруулан ажиллах шаардлагатай байна. Монголд дарга нарын тоо нь олдож, ажил гүйцэтгэх албан хаагчид нь чиг үүрэгтээ заасан ажлаа бус нэмэлт ажлуудад дарагдан буйд төрийн албан хаагчид сэтгэл гонсгор буйгаа хэлж байна. Дарга нар ард түмнээ дээрээс нь бус дэргэдээс нь харж, түмэн олонд үйлчлэх үүргээ хариуцлагатай ухамсарлан ажилламаар байна. Бүдэрч унасан нэгнийг татаж босгохоос бусад тохиолдолд ард иргэдийг хэзээ ч битгий дээрээс нь харж бай хэмээх ухаант ардын мэргэн үгийг төрийн эрх барих дээд байгууллагын даргын хувьд бүх шатны дарга нарт сануулж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

олон улсын байдал улам ээдрээтэй болж, зэвсэг зөрүүлсэн халуун цэгүүд улам олширч байгаа энэ үед Монгол Улс эдийн засгийн аюулгүй байдлаа хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, дотоод эв нэгдэл, бодлогын нэгдмэл байдал, уялдаа холбоогоо улам сайжруулж, тулаад ирэх ямар ч саад бэрхшээлийг туулж гарах үндэстний сөрөн тэсвэрлэх чадавхаа өсгөн бэхжүүлэх шаардлагатай байна. Ойрх Дорнодод дэгдсэн дайн байлдаан Ормузын хоолой хаагдсаны улмаас дэлхий даяар газрын тос, байгалийн хийн нийлүүлэлт татарч, энергийн эх үүсвэрийн хомсдол үүслээ. 10 гаруйхан хоногт байгалийн хийн үнэ бараг 2 дахин, газрын тосны үнэ 40 гаруй хувиар өслөө. Дэлхийн Монгол Улсад дэлхийгээс ангид эдийн засаг, дэлхийгээс хамаарахгүй үнэ ханш гэж байхгүй. Ийм хурцадмал байдал сунжирч үргэлжлэх болон өсөн нэмэгдэх аваас түлш шатахууны үнэ өсөх магадлал өндөр байна. Түлш шатахууны үнэ бүх юмны үнэ болж, хоол хүнс, бараа, үйлчилгээ бүгдэд шингэдэг. Олон улсын тээвэр логистикийн тогтолцоо алдагдах, хямрах эрсдэлүүд манай улсын импорт, экспортын өртөг зардал өсгөх, эдийн засагт ирэх дарамтыг нэмж болзошгүй байна. Бүс нутгийн тогтворгүй байдал үргэлжилсэн хэвээр байвал хөрөнгө оруулалт саарч, эдийн засгийн орчинд сүүдрээ тусгаж, экспортын гол бүтээгдэхүүн нүүрс, зэсийн эрэлт үнэ буурахад хүргэж мэдэхээр байна.

Улсын Их Хурал, Засгийн газар, банк, санхүүгийн байгууллагууд энэ бүх эрсдэлийг нарийн тооцоолж, үр дагаврыг нь бууруулахын төлөө өөрсдөөсөө хамаарах бүхнийг хийж, оновчтой бөгөөд шуурхай шийдвэр гаргаж, арга хэмжээ авах нэн шаардлагатай байна. Тухайлбал стратегийн бүтээгдэхүүн болох түлш шатахууны 3-аас 6 сарын хэрэгцээгээ үүцлэн нөөцлөх, нэг улсын хамаарлыг бололцооныхоо хэрээр багасгах, газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад хурд нэмэхэд онцгойлон анхаарч ажиллахаас өөр арга байхгүй. Сэргээгдэх эрчим хүчний дундаршгүй их нөөцөө ашиглан нарны илч, салхины хүчийг хүртэл журамлан хясаж, өөрсдийнхөө гэрэл гэгээг хааж тушсан гацаанаас өөрсдийгөө чөлөөлөх нь эрсдэлийг дунд хугацаанд бууруулахын төлөө хийх ажил, шийдэх асуудал болоод байна. Зээлээс зээл, өрнөөс өрийн хоорондох гинжин

хэлхээг тасалж, гадаадын банк Монголд үүдээ нээхэд хөндөгдсөн хууль, журмын түгжээг тайлж, хямд эх үүсвэр, чөлөөт өрсөлдөөний үр дүнгээр өндөр хүүгийн дарамтаас өөрсдийгөө чөлөөлөх хууль, эрх зүйн шинэчлэл хамгийн ихээр хүлээгдэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

олон улсын ээдрээтэй нөхцөл байдалд бид улсынхаа эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдалд тулгамдаж буй асуудлуудаа эргэн харж, дүгнэлт өгөх шаардлагатай байна. Гомбожавын Занданшатарын тэргүүлсэн Засгийн газраас хэрэгжүүлсэн төсвийн зарлагын хэмнэлт, экспортыг дэмжсэн бодлогын үр дүнд эдийн засаг эргэн сэргэж байна. Эдийн засгийн өсөлт 2025 онд урьдчилсан гүйцэтгэлээр 6,8 хувь гарлаа. Хөдөө аж ахуй, барилга, уул уурхайн салбарын сэргэлт эдийн засгийн өсөлтийг дэмжиж, худалдааны салбарын өсөлт удааширсан нь өсөлтийг сааруулсан ч, уул уурхайн салбарт газрын тосноос бусад бүтээгдэхүүний олборлолт өссөнөөр салбарын өсөлт сэргэж 10,6 хувьд хүрсэн байна. Харин сүүлийн 2 жил дараалан зудын хүндрэлийн улмаас агшсан байсан хөдөө аж ахуйн салбар 2025 онд сэргэж 33,2 хувь өслөө. Орон сууц, эмнэлэг сургууль, Багахангай-Хөшигийн хөндийн чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалт барилгын салбарын өсөлтийг дэмжиж 15 хувиар эдийн засаг өслөө. Экспорт 2026 оны 01 дүгээр сард 1,7 тэрбум долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 71,8 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд уул уурхайн салбар, тэр дундаа нүүрс, зэсийн баяжмалын экспорт голлон нөлөөлсөн байна. Инфляц 2 дугаар сарын эцсийн байдлаар 6,5 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 3,1 хувиар, өмнөх сараас 1 нэгж хувиар буурсан байна.

Цаашид бид эдийн засгийн өсөлтийг өрхийн хаалгаар оруулж өрхийн бодит орлогыг нэмэгдүүлж, хүндээ хүртээмжтэй болгох шаардлагатай байгааг онцлон сануулъя. Төсвийн орлого ч, зарлага ч экспорт, нүүрсний экспортоо даган тэлж байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого тогтвортой нэмэгдэж, 2025 оны байдлаар 30,1 их наяд төгрөгт хүрсэн бол нэгдсэн төсвийн нийт зарлага 2022 онд 16 хувиар, 2023 онд 24 хувиар, 2024 онд 36 хувиар нэмэгдсэн. Харин 2025 онд анх удаа 31,3 их наяд төгрөг болж буурсан нь Засгийн газрын хэрэгжүүлж байгаа зөв бодлого юм. Сүүлийн жилүүдийн төсвийн хэт тэлэлтийг даган төсвийн урсгал зардлын хэмжээ өнөөдөр 24 их наяд хүрч, улмаар шинэ баян цээж өвчтэй гэдэг шиг төсвийн бүх төрлийн урсгал зардал хамгийн багадаа 2 дахин нэмэгдсэн байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа 208 хуулийн 1024 заалтаар Монгол Улсын төсвийн урсгал зардлыг хуульчилсан байдаг. Энэ бүгдэд дүн шинжилгээ хийж, урсгал зардлыг хуулиар тогтоосон байдлыг өөрчилж байж, төсвийн дорвитой өөрчлөлт хийж чадахыг хууль тогтоогчид бид анхаарах хэрэгтэй. Улсын Их Хурлаас хэлэлцэн баталсан Төсвийн хүрээний мэдэгдэлд төсвийн нийт зардлын эдийн засаг дахь харьцааг 2026 онд 32,2 хувь, 2027 онд 30 хувь, 2028 онд 28,6 хувь байхаар үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгасан нь дэвшил байлаа. Төсвийн зардлын өсөлтийг ийнхүү хязгаарлаж байгаа нь төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, эрэлтийн гаралтай инфляцыг хязгаарлах замаар мөнгөний бодлоготой уялдуулж дунд хугацаанд инфляцын зорилтот түвшинд тогтворжуулахад хувь нэмрээ оруулах болно. Үүний үр дүнд дунд хугацаанд зээлийн хүү буурах, Засгийн газрын зээлжих зэрэглэл тогтвортой нэмэгдэх, төсвийн бодлогын орон зай бэхжих зэрэг ач холбогдлууд бий болно.

Эрхэм гишүүд ээ, энэ бүх эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, гадаад дотоодын хүчин зүйлсийг харгалзан эдийн засгаа сэргээх, иргэдийнхээ ахуй амьжиргааг өөд татах эрүүл орчныг бүтээхийн тулд Улсын Их Хурлын хаврын чуулганаар дараах асуудал, шийдэлд онцгой анхаарал хандуулахыг та бүхнээс хүсье. 1.Улсын Их Хурлын даргын хувьд эдийн засаг дахь төрийн хэт оролцооны буруу зуршлыг хумьж, хувийн хэвшлээ дэмжих, иргэнээ эдийн засгийн эрх чөлөөгөө эдлэхэд нь чөдөр тушаа болсон хүнд суртлаас чөлөөлөх “чөлөөлье” санаачилгыг дэвшүүлсэн. Зөвшөөрлийн тухай хууль, түүнийг дагалдсан 90 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, зөвшөөрөл нэртэй хориглолтын тогтолцоог хамтдаа нурааж, иргэнийхээ хийж бүтээх хүслийг хяссан хүнд суртлаас чөлөөлье. Зөвшөөрөл гэдэг зүсээ, нэрээ өөрчилж, бүртгэл, лавлагаа, тохирол, гэрчилгээ, дүгнэлтүүд болсон хүнд суртлын тогтолцоог халъя.

Чуулганы завсарлагаагаар Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшинээр ахлуулсан ажлын хэсэг бүтээлчээр ажиллаж, иргэд, бизнес эрхлэгчид, төр, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн олон талын оролцоотой цуврал хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, Зөвшөөрлийн тухай хууль болгон түүнийг дагалдах 90 гаруй хуулийн өөрчлөлтийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн байна. Хориглоогүй л бол зөвшөөрдөг байхаас татгалзах, олон төрлийн үйл ажиллагааг зөвшөөрөл хөөцөлдөн хүлээхгүйгээр мэдэгдээд шууд эхэлдэг болох, зөвшөөрлийн тоо, төрлийг эрс цөөлөх, шинээр олгох, сунгахад тавигдах шаардлага нөхцөл, бичиг баримт, шат дамжлагыг багасгахыг хөдөлмөрч ажилсаг хүмүүс санал нэгтэй дэмжиж байна. Бизнес эрхлэхэд учруулдаг захиргааны дарамтыг бууруулах, тогтвортой байдлыг нь хамгаалах, зөвшөөрлийн хүчинтэй хугацааг уртасгах, зарим төрлийн энгийн зөвшөөрөл мэдэгдлийг төрөөс салгаж мэргэжлийн холбоодод шилжүүлэх энэ хууль төрийн хүнд суртлыг бууруулах хандлагын дорвитой өөрчлөлтийн эхлэл болно гэдэгт итгэл төгс байна.

2.Зөвшөөрлийн тогтолцоог буруу биш зөв болгоход Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Төлбөрийн чадваргүйдлийн хууль, Арилжааны тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Нийтийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хууль, Татварын багц хуулийг цогцоор нь шинэчилж, хөрөнгө оруулалтад тулгарч байгаа хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгах шаардлагатайг баялаг бүтээгчид, бизнес эрхлэгчид өөрийнхөө хөлс хүчээр ахуй амьдралаа өөд татах хүсэлтэй хэн бүхэн хүсэж байгааг анхааран авч үзэх ёстой.

3.Хувийн хэвшлийн эрх зүйн байдлыг дордуулдаггүй, төр гэнэдүүлж шийдвэр гаргаж, гэнэт эргэж буцаж орон зай, зах зээл, бизнес төлөвлөгөө, зорилтыг нь нураадаггүй, хөрөнгө оруулагчдыг урьж авчирчхаад хөөж явуулдаггүй байхыг хуульчлан, хөгжил дэвшлийн түлш болсон хөрөнгө оруулалтыг дуудаж, дэмжих нэн шаардлагатай байна. Чөлөөтэй бизнес эрхлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хувийн өмч, хөрөнгө оруулалтыг хуульчлан хамгаалж, хуулиас давсан дүрэм, журам гаргахыг хориглож, төрийн бүх шатны шийдвэр эдийн засгийн утга агуулга дээр үндэслэх нь хөрөнгө оруулалтыг урин дуудах үндэс суурь юм. Иймд хувийн өмч, хөрөнгө, бизнест халдан түрэмгийлдэг байдлыг таслан зогсоож, хөрөнгө оруулагчид, хувийн хэвшил, иргэддээ ээлтэй Хөрөнгө оруулалтын тухай хуулийн өөрчлөлтийг яаралтай батлах шаардлагатай байна. Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль болон хөрөнгө оруулалтын орчинд саад учруулж байгаа хуулийн төслүүдийг боловсруулахаар Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Чулуунбилэгийн Лодойсамбуу нарын гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг ажиллалаа.

Ажлын хэсэг Одонгийн Цогтгэрэл даргатай Ардчилсан намын бүлгээс боловсруулсан Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний хуулиудыг нэгтгэн, улс төрийн намуудын зөвшилцлийн дор хамтран боловсруулж, хэлэлцэн батлах шаардлагатай гэж үзэж байна.

4.Улсын Их Хурлын хаврын чуулганаар ард иргэд, аж ахуйн нэгжүүдийн нуруун дээр ачаа дарамт болсон татварын ачааллыг бууруулах Засгийн газраас өргөн мэдүүлсэн Татварын багц хуулийг авч хэлэлцэнэ. Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд Нэмэгдсэн өртгийн албан албан татвар, Хувь хүний орлогын албан татвар 2 их наяд, аж ахуйн нэгжүүдийн татварын ачаалал 700 тэрбум, нийтдээ 2,7 их наядаар ачааллыг нь хөнгөлөх, жилийн 400 сая хүртэлх орлоготой жижиг бизнес эрхлэгч татвараа хялбараар тайлагнадаг болж татварыг 1 хувиар тооцон төлөх зэрэг зэрэг өөрчлөлтүүдийг тусгасан байна. Иймд Улсын Их Хурал, Засгийн газрын ажлын хэсгүүд хамтран ажиллаж иргэд, аж ахуйн нэгжүүдийн шаардлагад нийцсэн Татварын багц хуулийн өөрчлөлтийг цаг алдалгүй батлан гаргая. Татварын багц хуулийн төсөлд санал, дүгнэлт боловсруулах Лхагвасүрэнгийн Соронзонболд, Батбаярын Жаргалан нарын гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна.

5.Өнөөдөр жирийн иргэдийн амьдрал зээлээс зээл, өрнөөс өрийн хооронд өнгөрч байна. 10 жилийн өмнө жигнэсэн зээлийн дундаж хүү 17-гоос 20 хувь байсан бол өнөөдөр ч хэвээрээ байна. Эх үүсвэрийн өртөг нь өндөр, хугацаа нь бага, эдийн засгийн эрсдэл их, эрх зүйн орчин тогтворгүйн улмаас өндөр зээлийн хүү өрийн гинжин хэлхээнд улс орноороо оржээ. Европ, Азийн банкнуудыг Монголд урьж дуудсан нэгэнт эхэлсэн яриа хэлцлүүд бол хямд өртөгтэй зээлийн эх үүсвэр, чөлөөт өрсөлдөөний үр дүнд өндөр хүүгийн дарамтаас чөлөөлөгдөх эхлэл болно гэж үзэж байна. Зөвхөн зээлийн хүү төдий бус хөрөнгө оруулалтын орчин, санхүүгийн зах зээлийн өрсөлдөөн, бизнесийн санхүүжилтийн боломж, иргэдэд очих хүртээмж, цаашлаад эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой өргөн хүрээний бодлогын асуудал юм. Зээлийн хүү буулгах нь зөвхөн гадаадын банк оруулж ирээд шийдчих зүйл биш. Ойрын жилүүдэд эдийн засагт эзлэх төсвийн нөлөөг бууруулж, хэрэглэгчээс үйлдвэрлэгч, халамжаас хөдөлмөрт, импортлогчоос экспортлогч улс болж байж зээлийн хүү бага түвшиндээ хүрнэ.

Харин богино хугацаанд иргэд, үйлдвэрлэгчдэдээ илүү боломж нээхийн тулд Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах нь гадаадын банк орж ирж, санхүүгийн ноу-хау /know how/, шинэ стандарт, эрсдэлийн удирдлагын соёл, технологийн шинэчлэл, үр ашигтай банкны салбарын шинэ хөгжлийг эхлүүлэх болно. Санжаагийн Наранцогт Ерөнхийлөгчтэй Төв банкны бүрэлдэхүүн санаачилгатай ажиллаж Төв банкны бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчилж, даргын тоог цөөлж, 700 хүрээд байсан орон тоог 500 болгож оновчилж, банкны хуримтлагдсан алдагдлыг бууруулах, гадаадын банк оруулж ирэх, зээлийн хүүг бууруулах цогц судалгаа хийж нөхцөл байдалдаа бодитой үнэлэлт, дүгнэлт хийж ажилласанд талархалтай байна.

Иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах тухай Улсын Их Хурлаас батлан гаргасан тогтоолын хэрэгжилтийг хангуулахаар Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Банзрагчийн Түвшин, Нанзадын Наранбаатар нарын ажлын хэсэг чуулганы завсарлагаагаар ажилласны үр дүнд Банкны тухай хууль болон Төв банкны хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн болоод байна.

6.Улсын Их Хурал хаврын чуулганы хугацаанд Хүүхдийн эрхийг хамгаалах хуулийн хэрэгжилтэд хяналт тавихад онцгойлон анхаарна. Улсын Их Хурал гэр бүл, хүүхэдтэй холбоотой хэргийг тусгай орчинд мэргэшсэн шүүгч шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулах шийдвэрийг гаргасан билээ. 2026 оны 01 дүгээр сард шүүгчид нь томилогдсон дагнасан шүүх үйл ажиллагаандаа хэрэглэх Хүрэлбаатарын Баасанжаргал, Оюунсайханы Алтангэрэл нарын гишүүдээр ахлуулсан ажлын хэсгийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн Гэр бүлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хууль тогтоогчдын хувьд ч, өөрсдөө үр хүүхэдтэй ээж, аавуудын хувьд ч эн тэргүүнд шуурхай хэлэлцэн батлах шаардлагатай байна. Хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангахын тулд нөхцөл байдлыг тал бүрээс бүрэн бодитой тогтоох зорилгоор шүүгч нотлох баримтыг хэрэгжүүлдэг хуультай болно. Үүний хамт Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон нийгмийг цочроосон олон гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог эргэн сэргээж, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиудыг цаг алдалгүй хэлэлцэн баталж, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалцаа.

7.Тэтгэврийн тогтолцооны нөхцөл байдал, тулгамдсан асуудал бэрхшээлийг санхүүгийн салбарыг хөгжүүлэхтэй хамтатган авч үзэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өнөөдөр дан ганц улсын нийгмийн даатгалын сан шийдэл гарц, шинэ шатанд хүргэж чадахгүй нь тодорхой боллоо. Ахуй амьдралыг тэтгэж чадахгүй, хүн амын насжилт өсөж буй хурдыг гүйцэхгүй, гал унтраах маягаар аргацаасаар нөхцөл байдлаа бид бүрэн дүүрэн дүгнэх хэрэгтэй. Иймд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг дахин боловсруулж хэлэлцэн батлуулах шаардлагатай байна. Улсын нийгмийн даатгалын сан даатгадаг биш өөрөө даатгуулдаг, тэтгэврийн тогтолцоо өөрөө тэтгэвэрт гарч тэтгүүлдэг болсон нөхцөл байдлыг өөрчлөх хуулийг нэн яаралтай хэлэлцэн баталъя. Иргэн ирээдүйгээ дан ганц улсын биш, хувийн нэмэлт тэтгэврийн санд даатгах, орлогын олон эх үүсвэртэй болох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай, Гончигдоржийн Уянгахишиг нараар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна. Нийгмийн бодлого өөрөө зорилтот бүлгүүддээ хүрч байх нь нэн чухал юм. Иймээс Отгоны Саранчулуун, Жадамбаагийн Баясгалан гишүүдээр ахлуулсан хүнд ээлтэй, хүртээмжтэй орчин, тэгш оролцооны асуудлаар санал, дүгнэлт гаргах ажлын хэсэг ч үүний тод илэрхийлэл байх болно.

8.2027 оныг Эрүүл мэндийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулж Эрүүл мэндийн салбарын багц хуулиудыг шинэчлэх, батлах шаардлага үүслээ. Эрүүл мэндийн тухай хуульд салбарын нэгдсэн бодлого, засаглалын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгах тогтолцоо бүрдүүлэх, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд эрүүл мэндийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн засаглал, үйл ажиллагааг сайжруулах, даатгалын сангийн бие даасан, хяналт, хариуцлагын тогтолцоотой, ил тод болгох, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй зохицуулалтыг сайжруулах, нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэнд, эрүүл амьдрах соёл, хандлагыг түгээхийг тэргүүлэх чиглэл болгох, анхан шатны тусламжийг боловсронгуй болгоход бид анхаарах шаардлагатай байна. Иймээс эрүүл мэндийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор Даваасамбуугийн Ганмаа, Тогтмолын Мөнхсайхан, Буланы Бейсен нарын гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байна.

9.Транспэрэнси Интернэшнл /Transparency International/ байгууллагаас гаргадаг авлигын төсөөллийн индексийн үзүүлэлт сайжрах биш муудаж, урагшлах биш ухарч байгаа нь бидэнд ирж буй ноцтой анхааруулга юм. 2025 онд Монгол Улс 31 оноо авч, 10 байраар хойшилж, 182 орноос 124 дүгээр байрт орлоо. Бид Олон улсын байгууллагын дэлхийд танилцуулдаг тайлантайгаа мартах учиргүй. Өөрсдийнхөө толин дахь тусгалтайгаа заргалдан маргалдаад юуг ч өөрчлөхгүй, зөвхөн засаж залруулж өөрчлөх болно. Үүнд олон шалтгаан бий ч онцлон авч үзвэл байгалийн нөөц, баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах шийдвэр гаргахдаа үйл явц өөрөө ил тод бус, хариуцлага хангалтгүй байна. Төсвийн зарцуулалт, төрийн өмчит компаниудын засаглал сул, нуугдмал хаалттай байна. Шүгэл үлээгчийг хамгаалах хууль, эрх зүйн орчин тодорхойгүй байна. Авлигын эсрэг ард түмний шууд хараа хяналт хязгаарлагдмал байна. Авлига, албан тушаалын хэрэгтнүүд ял завших, халдашгүй эрхээр далайлган мөрдөлтөөс мөрдөн байцаалтаас зугтах, зайлсхийх байна.

Энэ удаагийн Улсын Их Хурлын онцгой зорилт, даалгавар бол олон улсын авлигын төсөөллийн индексээр арагшлах биш урагшилж, ахиц амжилт гаргах явдал юм. Өнөөдрийн эхэлж байгаа хаврын чуулганыг авлигын эсрэг эрх зүйн эрүүл орчин хөрс бүрдүүлж, хогийн ургамлыг уг үндсээр нь арилгах, хаврын тариалалт болгохын төлөө ухаан бодлоо уралдуулан мэтгэлцэхийг уриалж байна. Авлига, албан тушаалын гэмт хэргийн хохирогчид нь Монгол Улсын иргэд юм. Авлигын хохирол бол иргэн бүрийн эдлээгүй боломж, аваагүй цалин, биелээгүй мөрөөдөл, алдарсан итгэлцэл юм. Энэ хаврын чуулганаар хууль бусаар олсон хөрөнгө орлогыг илрүүлэх, хураан авах, нөхөн төлүүлэх, илүү ил тод, илүү хариуцлагатай, үр дүнтэй хуульчлахад бид анхаарах болно. Улс төр, төрийн өндөр албан тушаалтны нотолж чадаагүй хууль бусаар олсон орлогыг хураан авч, иргэн бүрд илүү өгөөжтэй, эрүүл мэнд, боловсролд зориулж эмнэлэг, сургууль барихад зарцуулдаг болох хуулийг энэ хаврын чуулганаар хуульчлан шийдвэрлэх хүсэл зоригтой байна. Энэ хуулийг боловсруулах ажлыг Нийтийн албан тушаалтны хөрөнгө хураах хуулийг санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Оюунсайханы Алтангэрэлд хариуцан ахлуулан ажиллуулж байна.

Үндсэн хуулийн цэцийн 10 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авсантай холбогдуулж Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүнээр ахлуулсан ажлын хэсгээс боловсруулсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газраас өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяагаар ахлуулсан Нийтийн өмчийн болон төрийн өмчит компанийн хуулийг батлан гаргах болно. Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга нарын боловсруулсан Олборлох салбарын ил тод байдлын хуулийг хэлэлцэн батлах нь ч авлигын төсөөллийн индексийг бууруулахад чухал алхам болно хэмээн үзэж байна. Улсын Их Хурлын даргын “чөлөөлье” санаачилга, эрчим хүчний болон газрын тосны бүтээгдэхүүний хараат байдлыг бууруулах тухай Их Хурлын тогтоолын дагуу Улсын Их Хурлын гишүүн Мөнхчулууны Энхцэцэг, Саруулсайханы Цэнгүүн нарын ажлын хэсэг идэвх санаачилгатай ажиллаж, 20 квт-аас доош үйлдвэрлэсэн сэргээгдэх эрчим хүчийг түгээх сүлжээнд холбоход хүлээдэг 6-аас 12 сарыг ажлын 11 хоног, 9-өөс 15 хоногийн шат дамжлагыг 3 болгон цөөлж, техникийн нөхцөл шаардахгүй болгон нарны илч гэрлийг хүртэл халхалсан хүнд суртлыг чөлөөлж чадлаа. Аймгийн төвүүдэд нарны хавтан, хураагуур станц барихад хөндөлссөн зөвшөөрөл, газар олгохыг хөнгөвчилж хөрөнгө санхүү босгох бэлтгэл орчин бүрдээд байна.

Мөн байгаль орчин, ногоон хөгжлийн асуудлыг цогцоор нь харж хууль тогтоомжийн давхардал, хийдлийг арилгахаар Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын ажлын хэсгийн үр дүнд ногоон хөгжлийг чөдөрлөсөн эрх зүйн зохицуулалтыг чөлөөлөх хуулийн шинэчлэлийг хийх ажлын хэсэг ажиллаж байна. Байгаль орчны салбарыг усгүйгээр төсөөлөхийн аргагүй. Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ч хариуцлагатай ажиллаж байгааг та бүхэндээ онцлон тэмдэглэе. Хөдөө орон нутагт 8200 гаруй иргэнтэй уулзахад олон удаа дахин давтагдаж байгаа асуудлуудад онцгойлон анхаарч, боловсролын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах, Ахмад настны тухай хуулийн ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд, Малчны тухай хуулиудын биелэлтийг шалгах ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Очирбатын Амгаланбаатар, Цагаанхүүгийн Идэрбат нараар ахлуулан шалган судалж, санал, дүгнэлт гаргах, хууль тогтоомжийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх хувилбарыг тодорхойлох, шаардлагатай шийдвэрийн төслийг боловсруулахаар ажиллаж байгааг та бүхэндээ онцгойлж хэлье.

Төрийн албан хаагчид сар тутам, улирал тутам, хагас жил тутам бүтэн жилээр бодлогын баримт бичгийн төрөл тус бүрээр гэхчлэн хамгийн багадаа 14-өөс 18 төрлийн тайлан бичиж байна. Төрийн албан хаагчдын нийт үйл ажиллагааны 70 хувь нь урьдаас төлөвлөөгүй гэнэтийн шинжтэй, тухай бүр удирдлагын заавраар хийгддэг тайлан мэдээлэл бэлтгэх ажлууд багтаж байна. Ийм учраас Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн бүтээмж үндсэн ажилдаа зарцуулах цагийг нэмэгдүүлэхийн тулд дэлхийн улс орнуудад баримталж байгаа Once-Only зарчим буюу ижил агуулга бүхий тайланг нэг удаа авч, дараа нь бусад байгууллагууд хэрэглэх хуулийн төслийг өргөн мэдүүлэхэд бэлэн боллоо. Энэ хуулиар төрийн байгууллага, албан тушаалтан цахим системд байгаа тайлан мэдээллийг төрийн албан хаагчаас давхардуулан шаардах, цаасан хэлбэрээр гаргуулан авахыг бүрмөсөн хориглоно. Цаашид Улсын Их Хурал баримт бичгийг олшруулан тараадаг биш, цахим хэлбэрээр танилцаж, цаасны зардлыг бууруулна. Иймд Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Цэндийн Сандаг-Очир нарын гишүүдийн боловсруулсан Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хууль, Засгийн газар дахь хяналтын тухай хуулиар эдгээр асуудлыг нэг мөр шийдэх болно.

Эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын чуулган бүрэн эрхийн хугацаандаа 119 удаа хуралдаад байгаа энэ үед ердөө 19 хувьд нь оролцсон гишүүн ч байна. Хурал чуулгандаа сууж сонгогчдоо төлөөлөх үндсэн ажлынхаа 81 хувийг тасалсан хууль тогтоогч байгаа цагт парламентын нэр хүнд, итгэл, дархлаа суларна. Нээлттэй парламентыг бүрдүүлж, иргэдийн хяналтыг бэхжүүлэх чиглэлээр Улсын Их Хурлын үйл ажиллагааг илүү ил тод, нээлттэй, цаас биш цахим, баримжаа сураг биш баримт нотолгоонд үндэслэн хөгжүүлэх зорилгоор чуулганы завсарлагааны хугацаанд Улсын Их Хурлын Тамгын газар eparliament.mn платформыг нэвтрүүллээ. Улсын Их Хурлын гишүүдийн ирц, санал хураалт, хурлын тов, өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, ажлын хэсгийн оролцоо, идэвх зэргийг бодит цагийн горимоор нээлттэй мэдээлж, эдийн засгийн, нийгмийн 4 үндсэн салбарын, 12 дэд бүлгийн, 160 гаруй үзүүлэлт бүхий их өгөгдөл, статистикийн дашбоардыг Улсын Их Хурлын гишүүд та бүхэнд тарааж, хэрэглүүлж эхэллээ.

Энэхүү дашбоард Улсын Их Хурлын гишүүдийн ирц, оролцоо, идэвхийг нээлттэйгээр харах боломжийг бүрдүүлэх бөгөөд иргэд, сонгогчдод ч гэсэн тэр сонгосон гишүүнийхээ ажлын тайлан, ирц болон идэвх оролцоог цаг тухайд нь хардаг шинэ соёл бүрдэх болно. Энэхүү дашбоардыг амилуулах зорилгоор хиймэл оюун ухааныг нэвтрүүлж, парламентын үйл ажиллагаанд ашиглах их өгөгдөл, судалгаа, мэдээлэл боловсруулахад ашиглаж эхлээд байгааг эрхэм гишүүд та бүхэндээ хэлье. Хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагаанд хиймэл оюуныг нэвтрүүлж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 378 хуульд шинжилгээ хийж, 1000 гаруй заалт нь хүний эрхийг зөрчсөн, хязгаарласан, шууд зөрчиж байна гэсэн дүн гарсан. Эрх чөлөөт Монгол Улсын иргэний Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг тушсан мянган чөдөр, мянган гох дэгээ байна. Улсын Их Хуралд өргөн барьсан хууль, тогтоолын төсөл бүрийн хүний эрхийг зөрчсөн, хязгаарласан эсэхийг хэн бүхэн d.parliament.mn-д зочилж хиймэл оюуны тусламжтайгаар дүн шинжилгээ хийдэг болсон нь эрх зүйн чөлөөлөлтөд технологийн дэвшил ашиглаж эхэлсний үр дүн юм.

Цаашид хүний эрхийг зөрчсөн хууль тогтоомжуудын давхардал, хийдлийг арилгахаар Сүхбаатарын Эрдэнэболд, Хүрэлбаатарын Баасанжаргал нарын гишүүдийн ажлын хэсэг ажиллаж байна. Мөн Улсын Их Хурлын Тамгын газар, Чинбатын Анар гишүүний ахалдаг Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны санаачилгаар Парламентын нээлттэй өгөгдлийн сан байгуулах ажлыг чуулганы завсарлагааны хугацаанд хэрэгжүүлж эхэллээ. Хуулийн төсөл, нэмэлт, өөрчлөлтийн текстийг онлайнаар нээлттэй байршуулж, гишүүн бүрийн санал хураалтын дүнг ил тод харуулах, хуулийн төслийн явцыг эрхэм гишүүд та бүхэн өөрсдийн iPad дээрээ нээлттэй харах бололцоог бүрдүүлсэн юм.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хаврын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөж байна. Ардчилсан орны ардчилсан парламентын дархлааг сулруулах биш бэхжүүлэх, цаашид парламентыг илүү хариуцлагажуулах талаас нь шүүн тунгааж, иргэдийн санал бодлыг тусган олноороо хэлэлцэх учиртай.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа талдаа орсон, дэлхий дахины хурцадмал байдал, төрийн хүнд суртлаас иргэн, хувийн хэвшлээ чөлөөлөх шаардлага, авлигын эсрэг бодлого, үйл ажиллагаанд бодитой өөрчлөлт гаргах, эдийн засгийн өсөлтийг өрхийн хаалгаар оруулах зорилгодоо тууштай байж, үндэсний эрх ашгаа эрхэмлэн, мэргэжлийн мэтгэлцээн өрнүүлж, олон ургалч үзлийг уралдуулан өндөр хариуцлагатай ажиллахыг та бүхнээс хүсье. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулган нээснийг мэдэгдье.

10.34 цаг

Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх оролцож байна. Монгол Улсын Ерөнхийлөгч таныг үг хэлнэ үү хэмээн индэрт урьж байна.

У.Хүрэлсүх: Эрхэм хүндэт ард иргэд ээ,

Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд ээ,

Эрхэм хүндэт зочид оо та бүхэнд энэ сайхан өдрийн мэндийг өргөн дэвшүүлье. Монголчууд бид өвлийг өнтэй давж, урин хавартай золгон учирч буй энэ сайхан цагт Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулган нээлтээ хийж байна. Сүүлийн жилүүдэд хүн төрөлхтөн дэлхий нийтээрээ геополитик, гео стратегийн ээдрээтэй цаг үеийг туулж, зөрчил мөргөлдөөн, дайн тулаантай дэлхий ертөнцөд амьдарч байна. Энэхүү олон улсын нөхцөл байдал манай улсын эдийн засаг, ард түмний ахуй амьдралд сөргөөр нөлөөлж буй хэдий ч улиран одож буй могой жил Монголчууд бидний хувьд гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж, түүхэнд тодоор бичигдэн үлдэх төрийн ажлуудыг амжилттай хийж, Монгол Улсын нэр хүнд олон улсын тавцанд өсөн бэхжиж, Монголчууд бидний баялаг түүх, бахдам соёл, суу алдрыг дэлхий дахинд сурталчлан таниулсан түүхэн онцгой жил байлаа.

Мөн хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн салбарт ахиц дэвшил гарч, ард иргэд, баялаг бүтээгчид, төр засаг хамтдаа хичээн зүтгэсний үр дүнд манай улсын эдийн засаг 6,8 хувиар өсөж, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 7 мянган ам.долларыг давж, худалдаа, хөрөнгө оруулалт нэмэгдэн, гадаад валютын нөөц 7 тэрбум ам.доллар болж, Монгол Улсын зээлжих зэрэглэл түүхэн дээд түвшиндээ бас хүрсэн байна. Улс орны аюулгүй байдлын баталгаа болсон хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлж буй Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 53 хүнсний үйлдвэр шинээр ашиглалтад орж, олон арван үйлдвэрүүд үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмж, мянга гаруй нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг манай баялаг үйлдвэрлэгчид өөрсдөө үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн сайхан амжилтыг бас гаргаж чадлаа. Буянт мал сүргийнхээ түүхий эдийг боловсруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах зорилготой Цагаан алт хөтөлбөр амжилттай хэрэгжиж, бодит үр дүн гарч байгааг тэмдэглэн хэлэхэд сайхан байна. Эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө идэвх санаачилгатай ажиллаж, ард иргэдийг ажлын байраар хангаж, төр засгийнхаа бодлого шийдвэрийг дэмжин, ачааны хүндийг үүрч, улс эх орныхоо эдийн засгаа хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй бизнес эрхлэгчид, баялаг бүтээгчид, нийт ард түмэндээ Монгол төрийн нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлье.

Эрхэм нөхөд өө, дэлхий дахины дэг журам өөрчлөгдөж, олон улсын харилцааны систем шинэ сорилтуудтай тулгарч, худалдаа, эдийн засгийн хүндрэл бэрхшээлүүд гарч буй энэ цаг үед Монголчууд бид үндэсний эв нэгдлээ улам бэхжүүлж, нэгдсэн бодлого, сахилга хариуцлагатай байж, энэхүү ээдрээтэй цаг үеийг бид даван туулах учиртай юм. Цаашид дэлхий нийтэд түүхий эд, хүнс, шатахууны үнэ өсөх, тээврийн зардал нэмэгдэх, нийлүүлэлтийн сүлжээ доголдох, инфляц нэмэгдэх, эдийн засгийн өсөлт саарах зэрэг бодит эрсдэлүүд байгааг Олон улсын байгууллага, судлаачид анхааруулж байна. Тиймээс Улсын Их Хурал, Засгийн газар дээрх цаг үеийн тулгамдсан асуудлыг урьдчилан тооцож, төсөв санхүүгийн нөөц боломжоо бүрэн дүүрэн дайчилж, эрсдэлийг сөрсөн зөв, оновчтой бодлогын арга хэмжээ авч нягт хамтран ажиллах нь зүйтэй хэмээн үзэж байна.

Улсын Их Хурлын хаврын чуулганаар хэлэлцэх хууль тогтоомжууд нь эдийн засгийн болзошгүй хүндрэл бэрхшээлийг хохирол багатай даван туулах, түлш, эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх, уул уурхай, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн

салбарын бүтээмжийг сайжруулах, экспортын шинэ зах зээлийг нээх, ард иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, татвар төлөгчдийн хэвийн үйл ажиллагааг хангах, татварын орчныг сайжруулахад чиглэсэн байх нь нэн чухал байна. Мөн дэлхийн болон улс орны нөхцөл байдал, цаг үеийн үнэн бодит мэдээ мэдээллийг иргэд, олон нийт, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад шуурхай өгч байх шаардлагатай юм.

Энэ удаагийн хаврын чуулганаар хэлэлцэх асуудлууд нь манай улсын ирэх он жилүүдийн хөгжлийн чиг хандлага, ард иргэдийн амьдралын чанарт шууд нөлөөлөх болно. Тиймээс хууль бүрийн цаана хүний эрх, эрх чөлөө, үндэсний язгуур эрх ашиг, улс орны хөгжил дэвшлийн асуудал яригдаж байдаг гэдгийг ямагт санаж, улс төржилтөөс ангид, судалгаа тооцоотой, шинжлэх ухаанч, ирээдүйг харсан шийдвэрүүдийг гарган ажиллах ёстой байна.

Түүнчлэн, энэхүү геополитик, гео стратегийн ээдрээтэй нөхцөл байдалд Монголчууд бид тэр тусмаа эрхэм төрийн түшээ та бүхэн ёс зүй, сахилга батыг чанд сахиж төрд итгэх ард түмний итгэлийг сэргээж, үндэсний эв нэгдлийг улам бататган бэхжүүлэх нь урьд урьдаас илүү чухал болоод байна. Бурхны сургаалд нэг сайхан үг байдаг юм. Хэрвээ чи зовлонгоос ангижиръя гэвэл зовлонгийн шалтгааныг ол гэж. Тэгээд бидэнд зовлон байна. Тэр зовлонгийн шалтгаан нь ёс зүйгүй, сахилга хариуцлагагүй байдал гэж үзэж байгаа юм. Жишээ нь улсын төсвийг батлахад бид ямар хариуцлагагүй ханддагийг та бид өөрсдөө мэдэж байгаа. Сүүлдээ төрийн тэргүүн хүртэл хориг тавьж байсан гэдгийг ч та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Тиймээс төрийн албаны бүх шатанд сахилга хариуцлага, ёс зүйг дээдэлж, хариуцсан ажилдаа эзний ёсоор хандаж, хийрхсэн улс төр, хэрүүл тэмцлээс ангид байж, бүх шатны төрийн байгууллагын хүнд суртал, бүтээмжгүй байдлыг халж, иргэндээ ээлтэй, нийгэмдээ үлгэр дуурайлалтай төрийн албыг бэхжүүлэх явдал нэн шаардлагатай байна. Төрийн бүх шатанд хариуцлагын тогтолцоог чангатгаж, хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан аливаа албан тушаалтанд зохих хариуцлага тооцдог байх зарчмыг баримтлан ажиллах нь зүйтэй. Төрд зүтгэж буй хэн боловч төгс сайн мэдлэггүй ч төгөлдөр сайн ёс суртахуунтай байх учиртай юм.

Ардчилсан парламентын засаглалтай манай улсын хувьд төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурал нь хууль тогтоохын зэрэгцээ хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм оршин тогтнох суурь, баталгаа нь болдог жамтай. Харин парламентын оршин тогтнох эх үндэс нь түүний гишүүдийн нэр төр, ёс зүйн манлайлал, сахилга хариуцлага, үлгэр дуурайллаас шууд хамаарч байдаг. Ёс суртахуунгүй иргэншил өөрөө мөхдөг гэж эрдэмтэн мэргэд сургаж ирсэн. Тиймээс Улсын Их Хурлын гишүүд өндөр ёс зүй, сахилга хариуцлагатай байж хууль дээдлэх нь Монголын парламентын нэр хүнд өсөж, парламентын дархлаа, ардчилсан засаглал батжин бэхжих үндэс суурь болно.

Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх, албан тушаалын уг сурвалж гагцхүү ард түмнээс эхтэй байдгийг та бид бүгд мэднэ. Парламент бол ард түмний хураангуй. Та бүхэн бол ард түмний төлөөлөл, төр засаг түмэн олныг холбодог гүүр нь юм. Улсын Их Хурлын танхимд хувь хүний хэрүүл маргаан биш улс орны хөгжил дэвшлийн төлөөх бодлогын мэтгэлцээн өрнөж, хувийн явцуу ашиг сонирхол биш улс орны язгуур эрх ашгийн төлөөх бодлогын хэлэлцүүлэг өрнөдөг байх учиртай. Түүнчлэн, ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүн таны хэлсэн үг, хийсэн үйлдэл бүр нийгэмд ёс суртахууны жишиг тогтоож, ёс зүйн дээд манлайлал үзүүлдэг байх ёстой юм. Нэр хүнд бол гагцхүү ёс зүйн өндөр шаардлагын дор

эзэндээ ирж, тэр хэрээрээ олны итгэл, хүндлэлийг хүлээдэг жамтай. Та бүхний төр түмнийхээ итгэлийг авч, төрийн сүлдэндээ тангараг өргөхдөө ард түмнийхээ элчийн хувьд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглаж, тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ хэмээн андгайлсан байдаг.

Тэгвэл ард иргэдийнхээ өндөр итгэл, өргөн дэмжлэгийн дор Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон хэн боловч хүний ёсыг умартан ёс зүйн алдаа гаргаж, өргөсөн тангаргаасаа няцах аваас Үндсэн хуульд заасны дагуу хариуцлага хүлээдэг байхыг ард иргэд, сонгогч олон төр засгаасаа шахан шаардаж байна. Энэ бол зүй ёсны шаардлага гэдэгтэй та бүхэн ч гэсэн санал нийцэх байх. Парламентын гишүүн авлига, албан тушаалын гэмт хэрэгт холбогдож, ёс зүйн ноцтой зөрчил гаргадаг ч Улсын Их Хурлын гишүүний дархан эрхээр халхавчилж, хууль шүүхийн өмнө иргэн бүр тэгш эрхтэй байх Үндсэн хуулийн зарчмыг хөсөрдүүлж байгаад ард түмэн маш их бухимдсаар байна. Улсын Их Хурал бол хэн нэгнийг хуулийн хариуцлагаас хамгаалах бамбай эсвэл гэмт хэрэгтнийг нуун далдлах орон байр биш юм. Парламентын эрүүл мэнд нь намуудын сахилга бат, гишүүн бүрийн хувийн хариуцлага, ёс зүйгээс шууд хамаарна. Ёс зүйгүй бол итгэл үгүй, итгэл үгүй бол засаглал үгүй юм. Итгэл алдарсан газар дархан эрх нь давуу их эрх болон хувирдаг гэмтэй байдаг. Хууль бол парламентад халдашгүй байдлыг олгодог бол харин ард түмний итгэл парламентад оршихуйн дархлааг нь олгодог гэдгийг байнга санаж байх хэрэгтэй.

Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгч төр засагтаа итгэх ард түмний итгэлийг сэргээх, эв нэгдлийг хангах, ардчилсан парламентын засаглал, парламентын дархлааг улам бататган бэхжүүлэх, Улсын Их Хурлын гишүүний ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Үүнийг зарим хүмүүс парламентын дархлаанд халдаж байна гэж шүүмжилж байгааг би мэдэж байгаа. Болгоомжлол байгааг ч бас хүндэтгэн ойлгож байна. Миний байр суурь бол маш тодорхой. Монголд ардчилсан парламентын засаглал хүчтэй байх ёстой юм. Хэн нэгний эрх мэдлийг нэмэх, хэн нэгнийг хэлмэгдүүлэх тухай би огт яриагүй. Ард иргэд ардчилсан сонгуулиар өөрсдийн элч төлөөлөгчөө сонгохдоо хуулиас дээгүүр аашлах дархан эрхийг бус, харин төрийн үйл хэргийг нэр төртэй, хариуцлагатай хөтлөөрэй гэж итгэл сэтгэлээ өгдөг юм. Итгэл эзэнтэйгээ үхдэг гэж үг ч байдаг.

Парламентын дархлаа гэдэг нь хуулийн хамгаалалтаас илүү ард түмнийхээ итгэл, сэтгэл дээр оршдог гэдгийг ямагт санаж явах учиртай. Гэтэл энэ их итгэл, сэтгэлийг умартан иргэд, сонгогчдынхоо дургүйцлийг дэвэргэх нь парламентыг дотроос нь нураах хамгийн том аюул гэдгийг санаж байх хэрэгтэй. Хэрэв та ард түмнийхээ итгэл, сэтгэлийг дааж байгаа бол энэ хууль таныг хамгаална. Үүнээс айх хэрэг огт байхгүй. Харин төрийн нэр хүндийг шавартай хутгаж, түмэн олныхоо итгэл найдварыг хөсөрдүүлж байгаа бол ард түмний шүүлтээс та бас ангид байж чадахгүй гэдгээ мэдэх ёстой. Манай ард түмэн төрийн сүлд минь өршөө хэмээн залбирч, амь нас, ажил үйлсээ даатган, сүүнийхээ дээжийг өргөж, төрт ёсоо дээдэлдэг түүхэн сайхан уламжлалтай ард түмэн.

Эрхэм төрийн түшээ та бүхэн энэхүү хуулийг баталснаар манай улсын ард иргэдийн төрдөө итгэх итгэл, парламентад тавих хяналт, оролцоо нэмэгдэж, улс төрийн нам, эвсэл, Улсын Их Хурлын гишүүдийн хариуцлага сайжирч, популизм буурч, нэр дэвшигчдэд тавих төрийн босго, шаардлага өндөрсөж, ард иргэдийн төр засагтаа итгэх итгэл сэргэх түүхэн ач холбогдолтой гэдгийг би онцлон тэмдэглэж хэлэхийг хүсэж байна. Төрийн түшээ хүний хамгийн том дархлаа бол ард түмнийхээ өмнө нүүр бардам зогсох нэр төр байх учиртай юм. Тиймээс энэхүү хууль нь парламентын гишүүдийг аливаа гэмт хэрэг, ёс зүйн ноцтой зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нэр төрийг нь хамгаалах эрх зүйн баталгаа нь болох ёстой. Төрийн түшээд та бүхэн түмний төлөө төр оршдог гэсэн зарчмыг үндэс болгон ард түмнийхээ хүсэл шаардлагыг хүндэтгэн улс үндэстнийхээ язгуур эрх ашгийг эрхэмлэн парламентын дархлааг бататган бэхжүүлэхийн төлөө энэхүү хуулийн төслийг бүх талаас нь хэлэлцэн судалж батална гэдэгт Төрийн тэргүүн итгэл дүүрэн байна.

Улсын Их Хурал, Засгийн газрын эрхэм гишүүд ээ, эрхэм нөхөд өө,

Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, манай ард түмний эв нэгдэл бол Монгол төрийн бодлогын цөмд ямагт орших учиртай. Бүх ард түмнээс сонгогдсон Төрийн тэргүүн Үндсэн хуульд заасны дагуу ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч тул улс орны язгуур эрх ашиг, ард иргэдийнхээ эрх ашиг, хүсэл тэмүүллийг нэгдүгээрт тавина. Өнөөдөр ард түмнийг бухимдуулж, сэтгэл санааг нь зовоож буй асуудал бол нийгмийн шударга ёсны хүсэмжлэл юм. Монголд хүн засагладаггүй, хууль засагладаг байх ёстой. Задарсныг нь засагладаг, ядарсныг нь хайрладаг төртэй байх ёстой. Ийм төр байсан, одоо байгаа, цаашид ч байх учиртай. Энэ бол Монгол төр шүү. Хууль шүүхийн байгууллага гэмгүй нэгнийг хэлмэгдүүлж, гэмт этгээдэд ял завшуулж огт болохгүй. Улсын Их Хурлын гишүүний халдашгүй эрхийг гэмт хэрэг, хууль цаазаас бултах, гэмт хэргээ хаацайлах бамбай болгож хэрхэвч болохгүй. Эрхэм төрийн түшээд та бүхэн өргөсөн тангарагтаа үнэнч байж эс чадвал ард түмэн сонгосон шигээ эргүүлэн татаж чадах хүчтэй гэдгийг онцгойлон сануулж байна.

Төрийн түшээ та бүхний хэлсэн үг, хийсэн үйлдэл олны өмнө ямагт ил байдгийг санаж, олон түмэн, залуу үе, хүүхэд багачуудад ёс зүйн манлайлал үзүүлж, зөв үлгэр дуурайллаар нийгмээ манлайлж, ард түмнийхээ эв нэгдлийг ямагт хамгаалж байх учиртай юм. Монголчууд бидний сонгож авсан парламентын засаглал бол манай улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, хөгжил дэвшлийн баталгаа нь болдог. Улс эх орныхоо өмнө тулгамдаж буй олон асуудлыг шийдвэрлэхэд парламентын засаглалыг улам бататган бэхжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Ард түмний итгэл үнэмшлийг шударга ёс сэргээж, ардчиллын үнэт зүйлсийг олон түмний оролцоо бэхжүүлж байдаг гэдгийг огт мартаж болохгүй.

Монголчуудад 1990 оны цагаан морин жил эрх чөлөөнийхөө төлөө тэмцэж, ардчилсан хувьсгалыг эхлүүлж байсан бол энэ гал морин жил Монголчууд бид ардчилсан төр засгаа бататган бэхжүүлэхийн төлөө ёс зүйн хувьсгалыг эхлүүлэх ёстой юм. Тиймээс түмэн олныхоо итгэлийг хүлээсэн төр засагтай улс орон хүчирхэгжин мандаж, хөгжин дэвшдэгийг санаж, төрийн түшээд нь ёс зүйтэй, төрийн албан хаагчид нь сахилга баттай, төр засаг нь тогтвортой, түмэн олонд эв нэгдэлтэй, ирээдүйдээ итгэлтэй байж улс орноо хөгжүүлэхийн төлөө хүчин зүтгэцгээе.

Төр төвшин, шашин тунгалаг, дэлхий амгалан байх болтугай. Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай. Баярлалаа.

10.50 цаг

Н.Учрал: Монгол Улсын Ерөнхийлөгч танд баярлалаа. Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн үйл ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье. Улсын Их Хурлын эрхэм гишүүд, зочид, төлөөлөгч та бүхэнд талархал илэрхийлье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА